



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/155

Өмнөдэлгэр сум

┌ Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.1, 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Хэнтий багийн нутаг “Янзганы даваа” (48.182488N, 109.960764E) гэх газар нутаглаж буй малчин Батчулууны Мөнхбаярын суурьт 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 26-131 дугаартай шинжилгээний хариугаар листериоз өвчин оношлогдсон тул 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн голомтын цэгээс 10 км-ийн радиуст хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Голомтын бүсэд ажиллан мал сүрэгт үзлэг тандалт хийж, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг шат дараатай зохион байгуулж ажиллахыг “Хэйлти анимал стронг” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид, холбогдох судалгаа, голомтын зураглал үйлдэхийг Хэнтий багийн Засаг дарга (А.Баянмөнх)-д тус тус даалгасугай.

3.Тус арга хэмжээтэй холбогдон гарах зардлыг Гамшгийн эрсдэлийн сангаас зохих журмын дагуу зарцуулж ажиллахыг нягтлан бодогчийн үүргийг түр хавсран гүйцэтгэгч (Ц.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Оюунгэрэл)-д, аймгийн Мал эмнэлгийн газарт цагийн байдлыг мэдээлэн ажиллахыг Мал эмнэлгийн тасагт тус тус үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР